

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТАГТ ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛСЭН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨГҮЙ
БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2023/25-21-ШТА-ГА

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317
Цахим хаяг: Erdenebaatar@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114
Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Отгонбаяр Утас: 89306788
Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn
Аудитор С.Гансүх Утас: 95908400
Цахим хаяг: Gansukhsa@audit.gov.mn
Аудитор Л.Мөнх-Оргил Утас: 99039344
Цахим хаяг: Munkhorgill@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум 2023 он

АГУУЛГА

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал.....	3
Товчилсон үгийн тайлбар.....	5
Аудитын ерөнхий зүйл.....	6
Бүлэг-1. Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 99.3 хувь байна.....	8
Бүлэг-2. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн зарим хөрөнгийг ашиглахгүй байна.....	17
Бүлэг-3. Орон нутагт зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна.....	21
Дүгнэлт.....	23
Зөвлөмж.....	24
Зөрчлийн нэгтгэл.....	25
Холбогдох байгууллагын санал, тайлбар	27
Аудитаар өгсөн албан шаардлага.....	32



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/29

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Аймгийн Засаг дарга, Аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Орон нутгийн өмчийн газар, Бүрэнтогтох, Их-Уул, Цагаан-Уул, Цэцэрлэг, Тариалан, Эрдэнэбулган сумдын засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудиторов, 2023 оны 8 дугаар
сарын 18-ны өдрийн 18/дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

“ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР
ӨГӨӨЖ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ӨГСӨН
АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	92/A2260468/ХӨА-2023/25-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
2	93/A2260468/ХӨА-2023/25-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
3	94/A2260468/ХӨА-2023/25-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
СЯ	Сангийн яам
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
АХБ	Азийн хөгжлийн банк
ЯОУХАБ	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ЗЗБУХ	Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил
ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан
УИХ	Улсын их хурал
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
НАМЭМ	Ногоон алт малын эрүүл мэнд
БНБУ	Бүгд найрамдах Беларусь улс
МЭНС	Мал эмнэлгийн нэгдсэн систем
МЭҮН	Мал эмнэлэг үржлийн нэгж
ХШҮДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар
МАА	Мал аж ахуй

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол “Аудитын сэдэв батлах тухай”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалыг үндэслэн, “Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

Засгийн газрын шугамаар Хөвсгөл аймагт хэрэгжүүлсэн Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнд Монгол улсын Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын газрын тэргүүлэх аудиторовын баталсан аудитын дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, үр дүнг Үндэсний аудитын газар болон Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх;
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Хөвсгөл аймгийн Хөдөө аж ахуйн салбарт 2016-2022 онд хэрэгжүүлсэн Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд болон төсөл хэрэгжүүлэгч холбогдох байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжсэн зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг хамрууллаа.

Аудитын хугацаанд талбарын ажлаар аудитын баг аймгийн ХХААГ, Мал эмнэлгийн газар, Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Төмөрбулаг, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Тариалан, Эрдэнэбулган суманд томилолтоор ажиллаж, Цагаан-Уул, Цэцэрлэг сумтай ZOOM, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Их-Уул, Тосонцэнгэл, Улаан-Уул, Мөрөн сумын төрийн байгууллагын албан тушаалтан болон хувийн хэвшлийн 17 аж ахуйн нэгж, 17 иргэнтэй цахим болон биечлэн уулзалт хийж, хяналтыг хэрэгжүүлсэн. Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ХААН банк, Төрийн банк, Голомт банк, Хас банкнаас мэдээлэл авч хамтран ажилласан.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-300, 3000-3200, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1:2020, 6817-5:202, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, уулзалт хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглалаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам
- Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитор С.Гансүх, Л.Мөнх-Оргил нар 2023 оны 05 дүгээр сарын 18-ны өдрөөс 08 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл:

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн болно. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын хязгаарлалт:

ХХААХҮЯ, Сангийн яам, төслийн нэгж нь Гадаадын зээл тусламжаар орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт, тайлагнал, хяналт шинжилгээ үнэлгээг зохион байгуулж, холбогдох баримт материалыг төсөл хэрэгжүүлэгч яам, төслийн нэгж дээр архивын нэгж үүсгэн хадгалдаг, мэдээллийн ил тод байдал хангагдаагүй нь орон нутагт аудит хийхэд хангалттай мэдээлэл байхгүй, аудитын хязгаарлалт бий болгож байна.

Хөвсгөл аймагт гадаадын зээл, тусламжийг бүртгэл, мэдээлэл хангалтгүйгээс хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн мөнгөн дүнг бүрэн тодорхойлох боломжгүй байна.

Үндсэн мэдээлэл:

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг ХХААХҮЯ, Сангийн яам төлөвлөж, төсөл хэрэгжүүлэгч нэгжийг сонгон шалгаруулдаг. Төсөл хэрэгжүүлэгч нэгж төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн холбогдох яаманд тайлан мэдээг хүргүүлж ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн Хөдөө аж ахуйн салбарт Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сан, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Жайка” зэрэг байгууллагын санхүүжилтээр гадаадын зээлээр 27,369.2 сая төгрөгийн 6 төсөл, тусламжаар 1,001.0 сая төгрөгийн 4 төслийг 2016 оноос 2022 онуудад хэрэгжүүлээд байна. Үүнд:

Гадаадын зээлээр санхүүжсэн төсөл:

- Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төслөөр нийт 1 сумын 1 аж ахуйн нэгжид 115.9 сая төгрөгийн төсөл/БНБУ-ын ЗГ-ын зээл/
- Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төслөөр 1 аж ахуйн нэгжид 926.0 сая төгрөгийн төсөл /АХБ-ны зээл/
- Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслөөр 4 аж ахуйн нэгж болон 22 иргэнд 4,574.4 сая төгрөгийн төсөл /АХБ-ны зээл/
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн төслөөр 1 аж ахуйн нэгжид 297.0 сая төгрөгийн төсөл /ЯОУХАБ/ЖАЙКА II шат/

- Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөр Хөвсгөл аймгийн бүх сумын 1,679 иргэн, 1 аж ахуйн нэгжид 18,675.7 сая төгрөгийн төсөл /Дэлхийн банкны зээл/
- Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн санхүүжилт төслөөр Хөвсгөл аймгийн 11 ААН, төрийн байгууллага, 110 иргэн, малчны 24 бүлэгд 2,780.2 сая төгрөгийн төсөл /НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан, Даян дэлхийн байгаль хамгаалах сан / хэрэгжүүлжээ. Тус төсөлд Бүрэнтогтох, Цагаан-Уул, Цэцэрлэг сум 2012-2017 оны хооронд хамрагдсан байна.

Гадаадын тусламжаар санхүүжсэн төсөл:

- Ногоон алт-малын эрүүл мэндийн төслийн санхүүжилт Цэцэрлэг, Цагаан-Уул, Улаан-Уул, Арбулаг, Алаг-Эрдэнэ нийт 5 суманд 244.2 сая төгрөгийн төсөл /Швейцарын Хөгжлийн агентлагаас буцалтгүй тусламж/
- Монгол ногоо төслийн санхүүжилтээр Мөрөн суманд 25 айл өрх, 6 цэцэрлэгт 70.8 сая төгрөгийн төсөл /Швейцарын Хөгжлийн агентлагаас буцалтгүй тусламж/
- Мерси кор ОУБ-аас 22 сумын ХАА-н тасаг, сумын мал эмнэлэгт 145.5 сая төгрөгийн төсөл
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын SECIM төслөөр Хөвсгөл аймагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр Тариалан, Эрдэнэбулган, Тосонцэнгэл, Мөрөн, Төмөрбулаг суманд 540.5 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн байна.

БҮЛЭГ 1: ГАДААДЫН ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 99.3 ХУВЬ БАЙНА.

1.1 Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хэрэгжилт хангалттай байна.

1.1.1. Орон нутагт Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээлийн төсөл арга хэмжээний хэрэгжилт 99.3 хувь байна.

Хөвсгөл аймагт Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээлээр 27,369.2 сая төгрөгийн санхүүжилттэй нийт 6 төсөл хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1- Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил (ЗЗБУХ) Нэмэлт санхүүжилт зээл /НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан /ХААХОУС/

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл нь НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хөнгөлөлттэй зээл, Даян дэлхийн байгаль орчны сан (ДДБОС)-ийн буцалтгүй тусламжаар Бүрэнтогтох, Цагаан-Уул, Цэцэрлэг, Их-Уул суманд 2012-2017 оны хугацаанд хэрэгжсэн байна.

Төслийн зорилго нь хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төсөлд хамрагдсан аймаг, сумдын малчин өрхүүд болон сумын төвийн иргэдийн ядуурлыг бууруулж, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн байна. Төслийн хүрээнд Цагаан-Уул, Бүрэнтогтох, Цэцэрлэг сумуудад хийгдсэн ажлуудын төслийн төгсгөлийн шатны болон 2017 оны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дараах байдлаар тусгасан байна.

Бэлчээрийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь зорилтын хүрээнд:

- Төсөлд хамруулахаар сонгогдсон 3 суманд 24 малчны бүлэг байгуулж, тэдгээрт 133.5 сая төгрөгийн дундын санг бүлгийн 662 орчим малчин өрх, 2475 ам бүлд хамааруулан төслийн үр шимийг хүртэж байхаар хүлээлгэн өгсөн байна.
- Төслийн хүрээнд 2012-2017 онд сумдад өвөлжөө, хаваржаа шинээр барих ажилд 71.8 сая төгрөг, мэдээллийн өрөө танхимыг тохижуулахад 29.0 сая төгрөг, мал эмнэлэг, үржлийн ажил, Мал угаалгын ванн, эмчилгээ тэжээлийн хашаа, эрсдэлтэй хаягдлын тусгай нүх, мал эмнэлгийн тоног төхөөрөмж, дэмжлэгийн хүрээнд 39.5 сая төгрөг, Цагаан-Уул суманд олон

үйлдэлт трактор 99.8 сая төгрөг, ус цуглуулах хөвийн далан байгуулахад 40.6 сая тус зарцуулсан байна. Мөн Цагаан-Уул суманд халаах төхөөрөмж бүхий гүн өрмийн худаг 1ш, Бүрэнтогтох суманд 4ш гүний худаг гаргасан байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд 2013-2017 оны хооронд нийт 898.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс нийт хөрөнгө оруулалтын 70 гаруй хувийг бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, хадлан бэлтгэлийг сайжруулах ажилд зарцуулжээ.

Зах зээлийн хөгжил бүрэлдэхүүн хэсгийн зорилтын хүрээнд: ХААН банк, Төрийн банкт хамтран ажиллах гэрээний үндсэн дээр 2012-2017 онд хөнгөлөлттэй зээл олгосон байна.

- Төслийн зүгээс 2016 онд орон нутгийн өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран байгуулсан 92 бүлгийн иргэдэд зээлийг олгох ажлыг зохион байгуулж, Төрийн банк, Капитал банк, ХЭДС-аас нийт 791.6 сая төгрөгийн зээлийг 84 бүлэгт олгосон. Төслөөс зээлийн 80 хувьд батлан даалт гаргасан. Мөн сүү цагаан идээ боловсруулах, оёдол эсгүүр, гутал хийх, хүлэмж, усалгааны систем, цөцгий цохигч зэрэг 81.6 сая төгрөгийн 74 ш тоног төхөөрөмж олгосон.
- Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд Гурван ивээл ХХК, Сэлэнгэ ХХК, Газар шороо ХХК, Далай ээжийн долгио ХХК-д батлан даалтын сангаас 140.0 сая төгрөгийн батлан даалт гаргаж, 313.0 сая төгрөгийн зээлийг 8 хувийн хүүтэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олгосон байна.

ЗЗБУХ төслийн хүрээнд 2020-2022 онд ХААН банк, Төрийн банкт байгуулсан гэрээний дагуу зээлийг нь банк өөрийн хөрөнгөөс гаргаж, төслөөс 25 иргэнд батлан дааж зээл олгосон байна. Тухайлбал: Банк зээл олгохдоо иргэнд 20.0 сая төгрөгийг 36 сарын хугацаатай, 10.8-13%-ийн хүүтэй, аж ахуйн нэгжид 75.0 сая төгрөгийг 60 сарын хугацаатай, 12-14%-ийн хүүтэйгээр Хөвсгөл аймгийн хэмжээнд 110 иргэн, 2 аж ахуйн нэгжид зээл олгосон байна.

Хүснэгт 3. Хаан банк, Төрийн банкаар олгосон зээлийн мэдээлэл /сая.төг/ 2022.12.31

Аймгууд	Иргэдийн зээл				ААН-д олгосон зээл		
	Тоо	Олгосон зээлийн дүн	Батлан даалтын тоо	Батлан даалтын дүн	Тоо	Олгосон зээлийн дүн	Зээлийн үлдэгдэл
ХААН банк	30	336.5	-	-	2	96.0	242.2
Төрийн банк	80	961.5	25	200.8	0	0	712.5
НИЙТ ДҮН	110	1,298.0	25	200.8	2	96.0	954.7

Эх сурвалж: Хөвсгөл аймаг дахь ХААН банк, Төрийн банкны мэдээллээс

Хүснэгтээс харахад иргэн, аж ахуйн нэгжид нийт 1,298.0 сая төгрөгийн зээл олгогдсоноос 2022 оны 12 сарын 31-ний байдлаар 954.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба зээлийн 343.3 сая төгрөг буюу 26 хувь нь эргэн төлөгдсөн байна. Зээл болон хүүгийн эргэн төлөлт хугацаа хэтрээгүй байна.

2- “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” :

Бүгд найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банк болон Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Тосонцэнгэл, Мөрөн сумуудад трактор болон дагалдах хэрэгслийг нийлүүлсэн гэж ХХААХҮ-ийн сайдын 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А-238 тоот тушаалын хавсралт болон төслийн нэгжээс ирүүлсэн судалгаанд тусгасан боловч аудитаар хянахад зөвхөн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд 2021 онд 33,920 евро буюу 115.9 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг Хургатай хайрхан ХХК нь Иргэн О.Аззаяагийн нэрээр хүлээн авч ашиглаж байгаа ба тоног төхөөрөмжийн үнийг 100 хувь төлж барагдуулсан байна.

Хүснэгт №2. БНБУ-ын засгийн газрын техник тоног төхөөрөмжийн туслалцаагаар Хургатай Хайрхан ХХК-ийн зээлээр авсан тоног төхөөрөмжийн жагсаалт

/евро/

№	Сум	Харил цагч	Олго сон он	Бүтээгдэхүүний нэр	Нэгж үнэ /евро/	Тоо хэм жээ	Нийт үнэ	Төлсө н дүн	Тайлбар
1	Цэцэрлэг	О.Азза яа	2021 он	Беларусь-82.1	16,570	1	16,570.	16,570	"Хургатай хайрхан" ХХК 115,882,168 төгрөгөөр худалдан авсан.
2				Хадуур КДН-210	3,100	1	3,100	3,100	
3				Тармуур ГВР-630	4,450	1	4,450	4,450	
4				Дөрвөлжин хаман боогч ППТ 160	9,800	1	9,800	9,800	
Нийт дүн							33.920	33.920	

Төсөл хэрэгжих үед техник тоног төхөөрөмжийн үнийг бүрэн төлсөн ба зориулалтын дагуу ашиглаж байна.

Тосонцэнгэл суманд 17,935.0 евро буюу 60.3 сая төгрөг, Мөрөн суманд 35,870 евро буюу 120.6 сая төгрөгийн нийт 180.9 сая төгрөгийн трактор болон бусад дагалдах хэрэгслийг нийлүүлээгүй ба хаана нийлүүлэгдсэн нь тодорхойгүй байна.

3- Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл /АХБ-ны санхүүжилттэй МОН-3338 /хөнгөлөлттэй зээл 2016.02.19 шийдвэр гарсан/

Тулгат олз ХХК нь Төрийн банкнаас жилийн 13.76 хувийн хүүтэй 10 жилийн хугацаатай 926.0 сая төгрөгийн зээлийг 2021 оны 3 дугаар сарын 31-нд авснаас Зээлийн батлан даалтын сангаас 420.0 сая төгрөгийг батлан даасан байна.

4-"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн санхүүжилт" төсөл /АХБ, Японы ядуурлыг бууруулах сан/

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт зээлийн хүрээнд Хөвсгөл аймагт 2 аж ахуйн нэгжид зээл, иргэд, хоршоодод тоног төхөөрөмж бараа материал олгож, 264 иргэнд сургалт зохион байгуулж нийт 4,574.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Төслийн хэрэгжилтийг графикаар харуулбал:

График 1



Нийт хөрөнгө оруулалтын 96% буюу 4,390.0 сая төгрөг хөнгөлөлттэй зээл, 3% буюу 158.3 сая төгрөг тоног төхөөрөмж, бараа материал, 1% буюу 26.1 сая төгрөг сургалтад зарцуулагдсан байна.

Тоног төхөөрөмж бараа материал олголтын талаар:

МУЗГ-аас хэрэгжүүлж буй “Мах сүүний анхдугаар аян”-ы хүрээнд ХХААХҮЯ, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “ХАА-н нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцаа” төсөлтэй хамтран мал аж ахуйгаас бэлтгэж буй сүү

ашиглалтыг сайжруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор “Ногоон алт” төсөл хэрэгжиж буй Улаан-Уул, Алаг-Эрдэнэ, Арбулаг сумдын Бэлчээр ашиглагчдын холбооны гишүүн 22 малчин өрх болон Мэлхий хадны цуурай, Дархад малын хишиг ундрах хоршоонд нийтдээ 61.2 сая төгрөгийн үнэ бүхий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ХХААХҮЯ болон төслийн ажилтнууд ирж хүлээлгэн өгсөн байна.

- Сургалтад хамрагдсан иргэдээс сүүний аж ахуй эрхэлдэг 22 өрхөд сүүний машин, 40л-ийн бетон, 20л-ийн бетон, хувин тус бүр 1 ширхэг, ааруул хатаах дэлгэц 3 ширхэг, сүүний шүүлтүүр 2 ширхэг нийт 37.6 сая төгрөгийн сүүний иж бүрдэл олгосон байна.

- Алаг эрдэнэ сумын Мэлхий хадны цуурай хоршоо, Улаан-Уул сумын Дархад малын хишиг ундрах хоршоонд нийт 23.7 сая төгрөгийн сүү боловсруулах тоног төхөөрөмж олгосон байна.
- Өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад 97.0 сая төгрөгийн хүнсний тусламжийн бараа нийлүүлсэн байна.

Зохион байгуулсан сургалтын талаар

- Төслөөс төслийн танилцуулга, нэмүү өртгийн сүлжээний үндсэн ойлголт, хамрагдах салбаруудын боломж, тулгарч буй асуудлууд, бизнес, санхүүгийн шинжилгээ, үнэлгээ, арилжааны банкнуудын хийдэг үнэлгээнээс ялгарах зүйлүүд, нийгэм байгаль орчны хамгааллын үнэлгээ, тавигдах шаардлагыг хангуулах, Азийн хөгжлийн банк болон МУЗГ-ын хууль, тогтоомжийн ялгаа болон ижил зүйлсийн талаар 72 иргэнд сургалт зохион байгуулж 3.0 сая төгрөг зарцуулсан байна.
- Сүү ноос ноолуур, зөгийн аж ахуй эрхлэгч 192 иргэнд сургалт зохион байгуулж 23.1 сая төгрөг зарцуулсан байна.

Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд Хөвсгөл аймагт ноос, ноолуур боловсруулах 2 аж ахуйн нэгжид 4,390.0 сая төгрөгийн 4.5 хувийн хүүтэй 5-7 жилийн хугацаатай зээлийг арилжааны банкаар дамжуулан олгосон байна. Үүнд: Жинст мөрөн ХХК-д хөөврөн сүлжмэл, ноолуур бэлтгэх зориулалтаар 390.0 сая төгрөг, ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зориулалтаар 500.0 сая төгрөгийг Голомт банкаар дамжуулан олгосон байна. Зээлийн хөрөнгийг үйлдвэрийн барилга засварлах, тоног төхөөрөмжийн шинэчлэлд зарцуулснаар Жинст мөрөн ХХК-ийн үйлдвэрийн хүчин чадал 2 дахин нэмэгдэж борлуулалт дунджаар 64.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнө нь Улаанбаатар хот, БНХАУ руу түүхий ноос, ноолуур ачуулдаг байсан бол 2022 оны байдлаар нэмүү өртөг шингээж үйлдвэрээс 316.3 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн бүрд түүхий эдийнх нь байршил, чанарыг агуулсан бар кодыг нэвтрүүлж амжилттай ажиллаж байна.

Жинст мөрөн ХХК-ий үйлдвэрийн байр, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг доорх зургаас харна уу.

Зураг 1. Төслийн өмнөх тоног төхөөрөмж




Зураг 2. Төслийн дараах тоног төхөөрөмж



Зураг 3. Төслийн өмнөх үйлдвэрийн байр



Зураг 4. Төслийн дараах үйлдвэрийн байр



Лидер кашемир ХХК-д ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зориулалтаар 3,500.0 сая төгрөгийг Хаан банкаар дамжуулан олгосон байна. Дээрх зээлийн хөрөнгөөр дараах ажлуудыг хийсэн байна. **Үүнд:**

- Компани зээлийг хонины ноос угаах үйлдвэрийн өргөтгөлийг Хөвсгөл аймгийн мөрөн суманд барьж ашиглалтад оруулсан ба одоогийн байдлаар бүрэн ашиглаж байна.
- Улаанбаатар хотод самнах, сүлжих үйлдвэрийн байрыг шинээр барьж, тоног төхөөрөмж худалдан авч үйлдвэрийг ашиглалтад оруулсан тул орон нутагт үр дүнг тооцох боломжгүй байна.

“Лидэр кашемир” ХХК-ийн барилга байгууламжийн зургийг харуулав.

Зураг 5 Шинээр ашиглалтад орсон сүлжих үйлдвэр



Зураг 6 Шинээр ашиглалтад орсон



Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа хонины ноос угаах үйлдвэр

5- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн төсөл /ЖАЙКА II шат/

Энэ төслийн хүрээнд Хөвсгөл аймагт Хөвсгөл эх ХХК мах сүүний фермийг өргөжүүлэх зорилгоор Хас банкнаас жилийн 8 хувийн хүүтэй 5 жилийн хугацаатай 297.0 сая төгрөгийн зээлийг авч зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Төслийн хүрээнд сүүний хөргүүр, махны зоорины хөргөлтийн тоног төхөөрөмж, сүү болон махны чиглэлийн үхэр зэрэг үндсэн хөрөнгүүдийн худалдан авсан байна. Хөвсгөл эх ХХК жилд 60 орчим сая төгрөгийн мах, сүүн бүтээгдэхүүнийг орон нутгийн зах зээлд нийлүүлж байна. Махны чиглэлээс олох ашиг нь бага сүүний чиглэлээс харьцангуй өндөр ашигтай ажилласан байна. Жилд ойролцоогоор 25,000 орчим литр сүү авч 2,500 л цөцгий, 1,666 кг аарц, 700 литр монгол архи боловсруулан зах зээлд нийлүүлж, 60.0 сая төгрөг, махны борлуулалтаас 20.0 сая төгрөг нийт 80.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж байна.

Зураг 7. Хөвсгөл эх ХХК-ийн үхрийн ферм



Зураг 8. Хөвсгөл эх ХХК-ийн үхрийн ферм




Зээлийг гэрээний дагуу хугацаанд нь төлж байна.

6- Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл /Дэлхийн банк/

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Хөвсгөл аймагт нийт 18,675.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хэрэгжилтийг графикаар харуулбал:

График 2:



Нийт хөрөнгө оруулалтын 90 % буюу 16,845.0 сая төгрөг хөнгөлөлттэй зээл, 0.02% буюу 4.0 сая төгрөг тоног төхөөрөмж, бараа материал, 0.08 % буюу 16.8 сая төгрөг сургалтад, 9.7 % буюу 1,809.9 сая төгрөг малчин өрхөд дэмжлэг үзүүлэхэд зарцуулагдсан байна.

Зээл олголтын талаар

ХААН банкаар 797 иргэнд 6,309.3 сая төгрөг, төрийн банкаар 882 иргэнд 10,535.7 сая төгрөг нийт 1,679 иргэнд 16,845.0 төгрөгийн зээлийг 3 хувийн хүүтэй, 3 хүртэл жилийн хугацаатай олгосон байна.

Техник туслалцааны талаар

- Аймгийн мал эмнэлгийн газрын хэрэгцээнд зориулж Rotenzo 55C510KC Android үйлдлийн системтэй 55" TV (зөөврийн хөлийн хамт), Tenveo TEVO-VHD102U Видео хурлын камер, Tenveo TEVO-NA100B Видео хурлын системийн чанга яригчтай микрофон нийт 4.0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.

Төвөөс алслагдсан орон нутгийн малын эмч мэргэжилтнийг оролцуулан цахим хурал сургалт зохион байгуулах чадавхыг сайжруулснаар мал эмнэлгийн салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдал сайжирч байгаагаас гадна салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч, халдварт өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээг үр дүнтэй, шуурхай зохион байгуулах боломжтой болсон байна.

Сургалтын талаар

- Сумдад ажиллаж байгаа хувийн малын эмч нарт зориулсан багц цагийн сургалт зохион байгуулж 9.8 сая төгрөг зарцуулсан байна.
- Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох, Жаргалант, Их-Уул, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Түнэл, Цагаан-Уул, Эрдэнэбулган сумдын 70 малчныг Малын эрүүл мэндийн суурь мэдлэг олгох сургалтад хамруулж 7.0 сая төгрөг зарцуулсан байна.

Дэмжлэг туслалцааны талаар

- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 110 дугаар тогтоолоор малчин өрх бүрд 0.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Хөвсгөл аймагт нийт 18,112 малчин өрхөд дэмжлэг үзүүлэхээс 13 өрхийн нэр данс зөрүүгээс олгогдоогүй байна. Нийт 1,809.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хүрээнд нийт 6 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээс “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийн хүрээнд Тосонцэнгэл, Мөрөн суманд трактор болон бусад дагалдах хэрэгсэл нийт 180.9 сая төгрөгийн хөрөнгийг нийлүүлээгүй ба бусад төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжсэн байна.

1.1.2. Төрийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлд үнэ төлбөргүй хүлээн авсан гэж тусгасан 328.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох боломжгүй байна.

Төрийн байгууллагууд Өрийн удирдлагын тухай хуулийн 24.5¹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4², -дахь заалтын дагуу зээл, тусламжаар хүлээн авсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгах үүрэгтэй. ХХААХҮЯ, МЭЕГ-аас харьяа байгууллага болон орон нутгийн төрийн байгууллагад ирүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа Улсын төсвийн хөрөнгө оруулалт, байгууллага хооронд үнэ төлбөргүй шилжин ирсэн, Засгийн газрын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн хөрөнгө эсэхийг нь тодорхойлохгүйгээр үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө гэж тусгадаг тул эх үүсвэрийг ялгах боломжгүй байна. Тухайлбал: Аймгийн мал эмнэлгийн газарт бүртгэлтэй 218.6 сая төгрөгийн 16 ширхэг мал угаалгын ванн, Арбулаг, Баянзүрх, Их Уул, Галт, Жаргал, Төмөр булаг, Эрдэнэбулган суманд 110.2 сая төгрөгийн арьс шир боловсруулах тоног төхөөрөмж зэрэг тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд тусгасан боловч эх үүсвэр нь тодорхойгүй байна.

Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс Их-Уул сумын ЗДТГ-т 27.1 сая төгрөгийн 1 үндсэн хөрөнгө, Цагаан-Уул сумын ЗДТГ-т 154.0 сая төгрөгийн 17 үндсэн хөрөнгө, Бүрэнтогтох сумын ЗДТГ-т 192.9 сая төгрөгийн 18 үндсэн хөрөнгө, Цэцэрлэг сумын ЗДТГ-т 109.1 сая төгрөгийн 16 үндсэн хөрөнгө нийт 483.1 сая төгрөгийн 52 үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахаас 463.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж, Бүрэнтогтох сумын ЗДТГ 19.9 сая төгрөгийн 1 хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ зөрчилд аймгийн Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

1.2 Хөдөө аж ахуйн салбарт зээлээр хэрэгжүүлсэн нийт төслийн 96.6 хувь нь үр өгөөжтэй байна.

1.2.1. Гадаадын зээлээр хэрэгжсэн төслийн хүрээнд хүлээн авсан хөрөнгө зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих төслөөс бусад төслийн хөрөнгийн ашиглалт хэвийн байна.

Хөвсгөл аймгийн хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээлийн хөрөнгөөр нийт 27,369.2 сая төгрөгийн 6 төсөл хэрэгжсэн ба зээлийн ашиглалтыг аудитаар хянаж үзэхэд дараах зөрчил байна. Үүнд:

1. Тулгат олз ХХК нь Төрийн банкнаас жилийн 13.76 хувийн хүүтэй 10 жилийн хугацаатай 926.0 сая төгрөгийн зээлийг Төрийн банкнаас 2021 оны 3 дугаар сарын 31-нд авснаас Зээлийн батлан даалтын сангаас 420.0 сая төгрөгийг батлан даасан байна. Төрийн банк, Тулгат олз ХХК хооронд хийсэн зээлийн гэрээнд хөргүүртэй 500 тонны зоорь, өвлийн хүлэмж барихаар гэрээнд тусгасан боловч зоорийг бариагүй, тухайн аж ахуйн нэгж нь зээлийн гэрээний дагуу хүү болон үндсэн зээлийг эргэн төлөөгүйгээс одоогийн байдлаар 125.1 сая төгрөг хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, батлан даалтын санг 420.0 сая төгрөгийн эрсдэлд оруулах магадлалтай байна.
2. Хөвсгөл аймгийн Их-Уул суманд 27.1 сая төгрөгийн өртөгтэй 60 м2 өвлийн хүлэмжийг барьж хүлээлгэн өгсөн боловч, өвлийн улиралд бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байна. Мөн ашиглагч иргэнтэй түрээсийн гэрээ хийгээгүй байна.
3. Зах зээл бэлчээрийн удирдлага төслийн хүрээнд Бүрэнтогтох, Цагаан-уул, Цэцэрлэг сумдын 24 малчны бүлэгт нийт 133.5 сая төгрөгийн дундын санг 2017 онд хүлээлгэн өгсөн боловч ашиглалт хангалтгүй байна. **Тухайлбал:** Бүрэнтогтох сумын дундын сан 47.3 сая төгрөгөөс одоогийн байдлаар 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Цагаан-уул сумын дундын сан 48.6 сая төгрөг, Цэцэрлэг сумын дундын сангийн 37.6 сая төгрөгийн талаар ямар нэгэн нотлох баримт байхгүй, Засаг дарга, төрийн албан хаагчдаас тодруулахад ямар ч мэдээлэл, баримт байхгүй байна. Зах зээл бэлчээрийн удирдлага

¹ Энэ хуулийн 24.1.1-д заасан төсөл хэрэгжүүлэх гэрээний хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль[7]-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэнэ

² Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. ... 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага...

төслөөс сумын Засаг даргатай байгуулсан гэрээ, сумын засаг дарга малчны бүлэгтэй байгуулсан гэрээнд заасны дагуу сумын удирдлагууд малчны дундын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ биелүүлээгүй байна. Иймд Бүрэнтогтох, Цагаан-Уул, Цэцэрлэг сумын засаг дарга нарт малчны дундын сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт хэрэгжүүлж, сангийн хөрөнгө дутсан бол нөхөн бүрдүүлж ажиллах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 ³ дах заалт, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 7.3 ⁴ дах заалт, сумын Засаг дарга, малчны бүлгийн хооронд байгуулсан гэрээнд заасан малчны дундын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй нийцэхгүй байна.

4. Лидер кашемир ХХК-д ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зориулалтаар 3,500.0 сая төгрөгийг Хаан банкнаас авч, зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотод самнах, сүлжих үйлдвэрийн байрыг шинээр барьж, тоног төхөөрөмж худалдан авч үйлдвэрийг ашиглалтад оруулсан тул орон нутагт ашиглалтыг хянах боломжгүй байна.

1.2.2. Малчдад олгосон зээл 16,845.0 сая төгрөг, 1,809.9 сая төгрөгийн дэмжлэг урт хугацаанд үр өгөөж өгөх төсөл болж чадаагүй байна.

Аудитаар олж авсан хяналт шинжилгээ үнэлгээний тайлангийн мэдээллээр хөдөө аж ахуйн салбарт олгосон Засгийн газрын шугамаар авсан зээлийн үр өгөөжийг дараах байдлаар тайлагнажээ. Үүнд:

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хувьд

- Малчдын 24 бүлэгт анх 124.8 сая төгрөгийн дундын санг бүрдүүлж, төслийн хэрэгжилтийн шатанд 13.9 сая төгрөгийн хүүгийн орлогоор өсөж, төслийн хугацаа дуусахад 133.5 сая төгрөгийн дундын санг хүлээлгэн өгсөн ба 662 орчим малчин өрх, 2475 ам бүлд хамааруулан төслийн үр шимийг хүртэх боломжтой болсон.
- Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд анх удаа гүн өрмийн худаг ашиглалтад оруулсан.
- Бүрэнтогтох суманд малын өвөлжөө, хаваржааны хашаа засварлаж 18 малчин өрх, 3,985 мал үр шимийг хүртэж байна.
- Батлан даалттай зээл олгосон байна.
- Төслийн хүрээнд 2015 оноос эхлэн сумын ЗДТГ-тай хамтран хадлангийн нөөц бүрдүүлэх зорилгоор 70,000 га газрыг хамгаалалтад авснаар хадлангийн хэмжээ нэмэгдсэн байна.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөр МУ-ын Засгийн газрын 2020 оны 12 сарын 213 дугаар тогтоол, 2021 оны 4 дүгээр сарын 110 тогтоолоор өвөлжилт хүндэрч болзошгүй аймаг, сумдын гамшгийн эрсдэлийг үнэлж, хохирол багатай даван туулахад, мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлийг даван туулах үйл ажиллагаа зэрэгт зориулж, дэлхийн банкны санхүүжилтээр 18,654.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, дэмжлэгийг малчдад олгосон байна. Үүнд:

- Арилжааны банкаар дамжуулан нийт 1,679 малчдад 16,845.0 сая төгрөгийн зээлийг 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй малчид болон мал бүхий иргэнд зээл олгосон.
- Малчин өрхөд дэмжлэг 1,809.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Тухайн төслийн үндсэн зорилгыг хангуулахад тавих хяналтын тогтолцоо байхгүй, банкны зүгээс зөвхөн зээлийн эргэн төлөлтөд анхаарч байна. Энэ нь тухайн үедээ малчдын амьжиргаанд эерэг нөлөө үзүүлсэн боловч урт хугацаанд үр өгөөж өгөх төсөл болж чадаагүй байна.

³ 3 сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Бусад төслийн хяналт шинжилгээ үнэлгээний тайланд улсын хэмжээнд хэрэгжсэн төсөл арга хэмжээг тусгаж орон нутагт хэрэгжсэн төсөл арга хэмжээг тусгайлан тооцоогүй байна.

Аудитын явцад Хөвсгөл аймагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр өгөөжийг тооцсон байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3: Хөвсгөл аймагт Засгийн газрын зээлээр хэрэгжсэн төслийн үр өгөөж

д/д	Хэрэгжсэн төсөл хөтөлбөр	Үр өгөөж
1	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл"-ийн үр дүнд Хургатай хайрхан ХХК ногоон тэжээлийн тариалалтаас 2021 онд 16,000 боодол өвс, 2022 онд 4,000 ш боодол өвс хурааж, тус сумын багуудын малчид болон сумын өвсний фонд хөнгөлөлттэй үнээр худалдан авдаг болсон байна.
2	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл	Төслийн хугацаанд 400м2 зуны хүлэмжийг ашиглалтад оруулж, нарийн ногоо тариалж хэрэглэгчдэд борлуулж байгаа боловч төслөөс авсан зээлийг зориулалтын дагуу бүрэн зарцуулаагүйгээс үр өгөөж бага байна.
3	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл	"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн санхүүжилт" төслийг хэрэгжүүлснээр ноос, ноолуурын үйлдвэрт ажлын байр нэмэгдэж, орон нутгийн ноос, ноолуурын бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэн. Төслийн үр дүнд 2 аж ахуйн нэгжид зээл, иргэд, хоршоодод сүү боловсруулах тоног төхөөрөмж бараа материал олгож, 264 иргэнд сургалт зохион байгуулснаар зах зээл дэх сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн үр өгөөж гарсан байна.
4	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн төсөл	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн төсөл"-ийн үр дүнд фермерийн аж ахуй орон нутагт бий болж жилд 80.0 сая төгрөгийн мах, сүүн бүтээгдэхүүнийг орон нутгийн иргэн, ААН-д нийлүүлж байна.
5	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	Мөн төслийн хүрээнд нийт 18,099 малчин өрхөд дэмжлэг 1,809.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ тухайн үедээ малчдад үр өгөөж болсон байна. Арилжааны банкаар дамжуулан нийт 1,679 малчдад 16,845.0 сая төгрөгийн зээлийг 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгосноор өрхийн жилд ойролцоогоор 1,516.1 сая төгрөгийн хүүгийн зардлыг хэмнэсэн байна. Дээрх үр өгөөж нь тухайн үедээ малчдын амьжиргаанд эерэг нөлөө үзүүлсэн боловч урт хугацаанд үр өгөөж өгөх төсөл болж чадаагүй байна. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжсэнээр аймгийн Мал эмнэлгийн газрын хэрэгцээнд зориулж техник тоног төхөөрөмж нийлүүлснээр Төвөөс алслагдсан орон нутгийн малын эмч мэргэжилтнийг оролцуулан цахим сургалт зохион байгуулах чадавхыг сайжруулснаар мал эмнэлгийн салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдал сайжирч байгаагаас гадна салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч, халдварт өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээг үр дүнтэй, шуурхай зохион байгуулах боломжтой болсон байна. Энэ үр өгөөж нь урт хугацаанд малын эрүүл мэндийг сайжруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл солилцоонд урт хугацааны үр өгөөжийг бий болгосон байна.
6	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн санхүүжилт төсөл	Бүлэг байгуулж, малчдын дундын санг байгуулсан боловч төсөл хэрэгжих явцад бүлгийн гишүүдэд зээл олголт хэвийн явж байсан боловч төсөл дууссаны дараа зарим дундын сангийн үйл ажиллагаа зогсонги байдалтай болсон байна. Цагаан-Уул суманд гүн өрмийн худаг гаргаснаар сумын төвийн иргэд гүний цэвэр усыг унд, ахуйд хэрэглэх болсон. Цагаан-Уул, Цэцэрлэг сумын нутагт 40.6 сая төгрөгийн үнэ бүхий Ус хуримтлуулах хөвийн далан барьснаар шинээр бэлчээр ашиглах боломжтой болсон байна.

Гадаадын зээлээр хэрэгжсэн төслийн хүрээнд тоног төхөөрөмж бэлтгэж, барилга байгууламж барих, засварлах, өргөтгөх ажлуудыг хийсэн, малчдыг дэмжих хөнгөлөлттэй зээл, бичил зээлийг олгосон боловч зарим зээлдэгч нар нь зээлийн зорилгыг бүрэн хангаагүй, зориулалтын дагуу ашиглаагүй, хугацаандаа эргэн төлөлт хийгээгүй, батлан даалтын санг эрсдэлд оруулсан, зарим тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй, орон нутгийн төрийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлэх тогтолцоог хууль, журамд тодорхойлоогүй, орон нутагт ажлын байр хэдээр нэмэгдэж, ядуурлын түвшин яаж өөрчлөгдөж байгааг бодитой тодорхойлж чадахгүй байгаа зэргээс харахад хөнгөлөлттэй зээл, дэмжлэгийн үр дүнг орон нутагт үнэн зөв тооцох боломжгүй байна.

БҮЛЭГ-2 ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙН ЗАРИМ ХӨРӨНГИЙГ АШИГЛАХГҮЙ БАЙНА.

2.1. Хөдөө аж ахуйн салбарт олгосон гадаадын тусламжийг амжилттай хэрэгжүүлжээ.

2.1.1. Гадаадын тусламжаар санхүүжсэн төслийн 93.2 хувийг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Хөвсгөл аймагт гадаадын тусламжаар хөдөө аж ахуйн салбарт 1,001.0 сая төгрөгийн 4 төслийг 2016 оноос 2022 онуудад хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. **Монгол улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл** /Secim/-Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хамтран Европын холбооны санхүүжилтээр **"Монгол улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"** /Secim/-ийг Хөвсгөл аймгийн Тариалан, Тосонцэнгэл, Мөрөн, Эрдэнэбулган сумдад 2017-2021 онуудад хэрэгжүүлсэн байна. Төслийн хүрээнд 2019 онд мах, сүү, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын ажил хийж, хэрэгжилт 90%-тай хэрэгжсэн талаар төсөл хэрэгжүүлэгчийн тайланд тусгасан байна.

Төслийн хүрээнд мах сүү боловсруулах, хүнсний ногоо тариалалтын талаар иргэдэд сургалт явуулж, 540.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг иргэн, ААН-д нийлүүлсэн байна.

Аудитаар хэрэгжилтийг хянаж үзэхэд Secim төслийн ихэнх арга хэмжээ хэрэгжсэн боловч дараах төслүүд бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд:

- Тариалан сумын Намнангийн ар гэдэг газарт сүүний хөргөлтийн төв байгуулах төслийн дагуу суурин болон зөөврийн хөргүүрийг ашиглан малчдын сүүг хөргүүрт хадгалан Эрдэнэт хот руу зөөвөрлөж Витафит ХХК-д нийлүүлэх зорилготойгоор төсөл хэрэгжүүлсэн байна. Төслийн дагуу суурин болон Зөөврийн хөргүүрийг авчирч Хөх хотод 2 хүнийг сургалтад хамруулсан боловч тухайн үедээ бэлтгэл ажлыг дутуу хангасан, нутгийн малчин иргэдэд төслийн талаар сайн ойлгуулаагүйгээс төсөл бүрэн хэрэгжээгүй байна. Төслийн хүрээнд ирсэн сүү хадгалах зориулалттай 52.0 сая төгрөгийн үнэ бүхий 5 тонны багтаамжтай суурин хөргүүрийг Тариалан сумын ЗДТГ-т шилжүүлж, сүү тээвэрлэх зориулалттай 19.5 сая төгрөгийн үнэ бүхий 5 тонны зөөврийн хөргүүрийг Хөвсгөл Титаник ХХК-д шилжүүлсэн байна. Тариалан сумын Намнангийн ар гэдэг газарт сүүний хөргөлтийн төв байгуулах төсөл хэрэгжээгүй байна.
 - Эрдэнэбулган суманд мал нядалгааны жижиг үйлдвэр байгуулах зорилгоор төслөөс Амуу буудай ХХК-д 16.0 сая төгрөгийн мал нядалгааны үйлдвэрийн шугамыг нийлүүлж махны иж бүрэн жижиг үйлдвэр байгуулах зорилготой байсан. Компанийн зүгээс үйлдвэрийн барилгыг барьж ашиглалтад оруулснаар төсөл хэрэгжих байсан боловч мал нядалгааны үйлдвэрийн барилгыг хүнсний эрүүл ахуйн стандартад нийцүүлж доторлох ажлыг дуусгаагүй тул одоог хүртэл үйлдвэрийг ашиглалтад оруулаагүй байна. Цаашид энэ төсөл хэрэгжих боломжтой гэж аудитын баг үзлээ.
2. **Ногоон алт болон Малын эрүүл мэнд төслүүд** нь 2016 онд дууссан бөгөөд уг төслүүдийн үргэлжлэл болгон Ногоон алт, Малын эрүүл мэнд төслийг нэгтгэн **Ногоон алт-Малын эрүүл мэнд** нэртэйгээр 2017 оны 01 дүгээр сараас 2021 оны 9 дүгээр сар хүртэл Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй хэрэгжүүлсэн байна.

Ногоон алт - Малын эрүүл мэнд төсөл нь Хөвсгөл аймгийн Арбулаг, Алаг-Эрдэнэ, Цагаан-Уул, Цэцэрлэг, Улаан-Уул сумуудад хэрэгжсэн байна. Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- “Хариуцлагатай нүүдэлчид” бэлчээрийн МАА-н зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд MNC 6895:2020 стандарт боловсруулж батлуулсан байна.
- Аймаг, сумын түвшинд МЭНС-ийн хэрэглээг төлөвшүүлэхэд зориулсан 13.2 сая төгрөгийн 22 ширхэг ухаалаг төхөөрөмж нийлүүлсэн.
- Сумын мал эмнэлгийн тасаг, МЭҮН-ийн малын эмч, мэргэжилтнүүдийн хэрэгцээнд зориулсан 5.7 сая төгрөг 19 ширхэг утасгүй хэвлэгч нийлүүлсэн байна.

- Цэцэрлэг суманд шинээр мал эмнэлэг барилга барихад зориулж 20.0 сая төгрөг зарцуулсан.
- Цэцэрлэг сумын мал эмнэлгийн тасагт техник хэрэгсэл 5.0 сая төгрөг
- Баянзүрх суманд 10 сая төгрөгийн мал эмнэлгийн барилга барихад дэмжлэг үзүүлсэн.
- Аймгийн мал эмнэлгийн газарт 14.7 сая төгрөгийн хурлын танхимын тавилга, техник хэрэгсэл, нэмэлт санхүүжилтийн дансанд 35,2 сая төгрөг шилжүүлэн өгсөн байна. Энэ хөрөнгөөр аймгийн Мал эмнэлгийн газар, сумдын мал эмнэлэг, үржлийн албанд нийлүүлсэн техник тоног төхөөрөмжийн үнэ, Цэцэрлэг сумын мал эмнэлгийн барилгыг дуусгахад зарцуулсан байна.
- Арбулаг, Алаг-Эрдэнэ, Цэцэрлэг, Улаан-Уул, Цагаан-Уул суманд 6 сая төгрөгийн ногоон тэжээлийн үр нийлүүлж, эмэгтэйчүүдийг дэмжих жижиг төсөлд 2 сая төгрөгийн тусламж
- Ногоон алт төсөл малчдад хэрэглээний зориулалтаар зээл олгох зориулалттай дундын санг 50 хувийг малчин өрхөөс, 50 хувийн төслөөс нийт 162.4 сая төгрөгийн эх үүсвэртэйгээр 2018 онд үүсгэн байгуулсан байна.

3. Монгол ногоо төслийн талаар

Швейцарын хөгжлийн агентлаг Хөдөө аж ахуйн, хүнсний аюулгүй байдлын хөтөлбөрийн санхүүжилтээр Монгол улсын хэмжээнд Хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар хөдөө, орон нутгийн жижиг тариаланчид, хот

Зураг 9: Хүлэмж



суурин газрын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулж өрхийн тариалалтыг дэмжих зорилготой 2016-2023 оны хооронд хэрэгжүүлсэн байна. Аудитаар төслийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэхэд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд жишиг гудамж, загвар өрх байгуулж, 2019 оноос 12 дугаар багийн 25 өрхөд хэрэгжсэн ба тус сумын 2, 3 дугаар багийн 15 өрхөд 2023 онд үргэлжлэн төсөл хэрэгжиж байна. Төслийн хүрээнд дараах чиглэлээр хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнд:

- Төсөлд хамрагдсан айл өрхүүдийн дунд худаг гаргаж холболт хийсэн ба хүлэмж, ус хуримтлуулах сав, үр үрсэлгээ өгч, хүнсний ногоо тариалах, арчилж, ургуулах талаар арга зүйн зөвлөгөө өгсөн байна.
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын жишиг гудамжаар сонгогдсон өрхүүдэд 15 хүлэмж, 2 худаг, багаж тоног төхөөрөмж, үр үрсэлгээ нийт 63.9 сая төгрөгийн хөрөнгийг буцаан төлөлтгүйгээр олгосон байна.
- Мөрөн сумын “Сод эрдэм” сургууль, “Дэлгэрмөрөн цогцолбор” сургууль, АвьАвьяас сургууль, 4 дүгээр цэцэрлэг, 11 дүгээр цэцэрлэг, 15 дугаар цэцэрлэгт 6.9 сая төгрөгийн үнэ бүхий хүлэмж, багаж, тоног төхөөрөмж олгосон байна.

4. Мерси кор Монгол дахь олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд тусламжаар сумын Мал эмнэлэг, үржлийн тасагт нэг бүр нь 4.5 сая төгрөгийн вакцины хөргүүрийг 22 суманд нийлүүлсэн байна.

2.1.2. Төрийн байгууллагууд тусламжаар хүлээн авсан 76.2 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Орон нутгийн төрийн байгууллагууд гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс хүлээн авсан үндсэн хөрөнгө бараа материалыг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгах үүрэгтэй. Гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн Secim төсөл, Ногоон Алт төсөл, Монгол ногоо, Мерси кор ОУБ-ын төслөөс хүлээн авсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдлыг аудитаар түүвэрлэн хянаж үзэхэд төрийн байгууллагуудад нийт 194.7 сая төгрөгийн 45 үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахаас 76.2 сая төгрөгийн 13 хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

Мерси кор ОУБ-ын тусламжаар сумын Мал эмнэлэг, үржлийн тасагт нэг бүр нь 4.5 сая төгрөгийн вакцины хөргүүрийг 22 суманд нийлүүлж, Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгүүлэхээр шийдвэрлэсэн боловч Алаг-Эрдэнэ, Арбулаг, Бүрэнтогтох, Баянзүрх, Жаргалант, Рэнчинлхүмбэ, Рашаант, Тосонцэнгэл, Түнэл, Цагаан-Үүр, Улаан-Уул, Эрдэнэбулган сумууд нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Мал эмнэлгийн газар нь Ногоон алт-Малын эрүүл мэнд төслөөс 25.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөс 20.0 сая төгрөгөөр баригдсан Цэцэрлэг сумын 45.0 сая төгрөгийн өртөгтэй мал эмнэлгийн барилгыг бүртгэлд тусгахдаа 25.0 сая төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэсэн байна.

Аудитаар илэрсэн зөрчлүүд нь Өрийн удирдлагын тухай хуулийн 24.5⁵, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4⁶-дахь заалттай нийцэхгүй байна. Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй 51.2 сая төгрөгийн зөрчилд Орон нутгийн өмчийн газарт, нягтлан бодох бүртгэл, тайланд дутуу тусгасан 25.0 сая төгрөгийн зөрчилд Мал эмнэлгийн газарт зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл дууссаны дараах үр өгөөж хангалтгүй байна.

2.2.1. Ашиглагч байгууллагууд 100.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй байна.

Аудитаар нийлүүлсэн тоног төхөөрөмжийг ашиглахгүй байгаа дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

“Монгол улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”ийн хүрээнд:

- Хөвсгөл аймгийн Тариалан суманд сүүний нэмүү өртгийн сүлжээний хүрээнд 52.0 сая төгрөгийн 5 тонны сүүний хөргөлтийн танк, нийлүүлж, Төсөл хэрэгжүүлэгч Сүүний хөргүүрийг Тариалан сумын ЗДТГ-ын хашаанд буулгаж төслийг дуусгаагүй орхисон байна. Одоогоор сүүний хөргүүрийг бүртгэлд тусгаж, ашиглаагүй байна.
- Эрдэнэбулган суманд мал нядалгааны жижиг үйлдвэр байгуулах зорилгоор төслөөс Амуу буудай ХХК-д 48.0 сая төгрөгийн махны хөргөгч, 16.0 сая төгрөгийн мал нядалгааны үйлдвэрийн шугамыг нийлүүлсэн. Компанийн зүгээс үйлдвэрийн барилгыг барьж ашиглалтад оруулснаар төсөл хэрэгжих байсан боловч мал нядалгааны үйлдвэрийн барилгыг хүнсний эрүүл ахуйн стандартад нийцүүлж бариагүйгээс одоог хүртэл үйлдвэрийн шугамыг ашиглаагүй байна.
- Мөрөн суманд Мон-дэвш ХХК-д 32.0 сая төгрөгийн махны хөргөлтийн төв байгуулж хүлээлгэн өгсөн боловч газрын асуудлаас шалтгаалан саатаж одоог хүртэл ашиглаагүй байна.

Төслөөр хүлээн авсан хөрөнгийг ашиглахгүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 4.1.2⁷-дахь заалттай нийцэхгүй байна.

Төслөөс хэрэгжүүлсэн хөрөнгийг ашиглахгүй байгаа шалтгаан нь төслийн үр шимийг хүртэгч байгууллагуудын бэлтгэл ажиллагаа хангагдаагүй байхад төслийг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

2.2.2. Тусламжаар олгосон зарим төсөл, арга хэмжээний хөрөнгийг ашиглахгүй байгаагаас үр өгөөж бага байна.

Хөвсгөл аймагт гадаадын тусламжаар 1,001.0 сая төгрөгийн 4 төслийг 2016 оноос 2022 онуудад хэрэгжүүлж дууссан байна. Тусламжаар хэрэгжсэн төслийн үр өгөөжийг хүснэгтээр харуулбал:

⁵ Энэ хуулийн 24.1.1-д заасан төсөл хэрэгжүүлэх гэрээний хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль[7]-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэнэ

⁶ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. ... 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага...

⁷ Төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх

Хүснэгт 4. Тусламжаар хэрэгжсэн төслүүдийн үр өгөөж

д/д	Хэрэгжсэн төсөл хөтөлбөр	Үр өгөөж
1	Монгол ногоо төслийг хэрэгжих хугацаанд 25 өрх, 5 сургууль цэцэрлэг хүлэмж, тоног төхөөрөмжөөр үнэ төлбөргүй хангагдсан байна.	Төслийн үр дүнд жишиг гудамжны айл өрхүүд хашаандаа эрүүл ногоог тариалан ургуулж хүнсэндээ хэрэглэхээс гадна зах зээлд борлуулж, өрхийн орлогоо нэмэгдүүлэх ач холбогдолтой болсон байна. Төслийн үр дүнд Төсөл хэрэгжсэн айл өрх хүлэмжид нарийн ногоогоо тарихаас гадна ил талбайд төрөл бүрийн нарийн ногоо, мод, жимс тарьж өөрсдийн хэрэгцээг хангаж, илүүг зах зээлд борлуулдаг болсон байна. Сургууль, хүүхдийн цэцэрлэгүүд хүлэмжид нарийн ногоо тариалснаар хүүхдийн хоолны амин дэмийн хэмжээ, нарийн ногооны хэрэглээг нэмэгдүүлсэн үр өгөөж гарсан байна.
2	Ногоон алт малын эрүүл мэнд төсөл	- Бэлчээрийг төлөвлөлттэй нүүдэллэн сэлгэж ашиглах болсноор 5 сумын 200 хүртэлх га газрыг нөхөн сэргээсэн байна. - Цагаан уулд 30-80 га газарт ногоон тэжээл тариалж 50 хувь, Арбулаг суманд 10 га, Алаг-эрдэнэ 10 га, Цэцэрлэг суманд 5 га газарт ногоон тэжээл тариалдаг болсноор сумын өвсний фондын 50 хүртэл хувийг ногоон тэжээлээр хангадаг болсон байна. - Мал эмнэлгийн үйлчилгээнд гарал үүслийн цахим систем, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, вакцин, туулга хийсэн байдлын цахим системийг нэвтрүүлснээр малын гаралтай бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд борлуулах, суурь тавигдсан байна. - Малчдад малын эрүүл мэндийн анхан шатны боловсрол олгох, түүхий эдийг зөв зохистой бэлтгэж, борлуулах суурь мэдлэг олгосноор малчдын орлогыг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал Алаг-Эрдэнэ сумын малчид өмнө нь ашигладаггүй байсан сарлагийн хөөврийг самнаж үндэсний үйлдвэрт нийлүүлэх болсноор жилд 5 тонн орчим хөөвөр борлуулж 100 гаруй сая төгрөгийн орлого олдог болсон байна. - Бэлчээр ашиглалтын 49 хэсэг бэлчээр ашиглах гэрээ хийж, малчин өрхийн бэлчээрийн талбайг газар зохион байгуулалтын цахим системд бүртгэдэг болсноор бэлчээрийг уул уурхай болон бусад зориулалтаар ашиглах эрсдэлийг бууруулсан байна. - Хөвсгөл аймаг МАА-н стратеги төлөвлөгөөтэй болсноор гадаад дотоодын хөрөнгө оруулагч, зээл тусламжийг мал аж ахуйн салбарт татах боломжтой болсон байна. - Төслөөс 5 сумын малчин өрхийг хамруулан бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулж төсөл хэрэгжүүлэх бааз суурьтай болсон байна. - Малчдад хэрэглээний зориулалтаар зээл олгох зориулалттай дундын сан нь 2022 оны 12 сарын 31-ний байдлаар 264.9 сая төгрөг, хуримтлагдсан хүү 87.0 сая төгрөгийн нийт 351.9 сая төгрөгийн эх үүсвэртэй болсон байна.
3	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх SECIM төсөл	- Төслөөр мах, сүү, ногооны үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжсэнээр орон нутагт үйлдвэрлэсэн эрүүл хүнсээр иргэдийг хангах болсон байна. - Төслийн үр дүнд аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлдэг бүтээгдэхүүний чанар, нэр төрөл нэмэгдсэн байна
4	Мерси кор Монгол дахь олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл	Вакцины хөргүүрийг 23 суманд нийлүүлснээр Малын өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн хадгалах боломжтой болсон.

Төсөл үр дүнтэй хэрэгжсэн боловч төсөл дууссаны дараа зарим хөрөнгийг ашиглахгүй байна. Тухайлбал:

Secim төслийн хүрээнд хүлээн авсан Тариалан суманд нийлүүлсэн 5 тонны сүүний хөргүүр, Мөрөн сумын Мөрөн буян ундрах ХХК-д сүүний борлуулалтын цэг, Эрдэнэбулган сумын Амуу

буудай ХХК-д нийлүүлсэн мах нядалгааны үйлдвэрийн шугам, Мон-Дэвш ХХК-д нийлүүлсэн махны хөргүүрийн төв зэрэг хөрөнгүүдийг одоог хүртэл тогтмол ашиглаагүйгээс үр өгөөжийг нь гаргаагүй байна.

Тусламжийн хөрөнгөөр нийт 1001.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс 194.7 сая төгрөгийн хөрөнгийг төрийн байгууллагад, 806.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Хувийн хэвшилд олгосон хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг тооцож хяналт тавих субъект тодорхойгүй тул тусламжаар авсан хөрөнгийн үр дүнг тооцох боломжгүй байна.

БҮЛЭГ 3: ОРОН НУТАГТ ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

3.1. Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналтын үр дүн хангалтгүй байна.

3.1.1. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээний хяналтад орон нутгийн төрийн байгууллагыг оролцуулах хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй байна.

Сангийн яам, ХХААХҮЯ-аас зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлсэн боловч орон нутгийн төрийн байгууллага, ХАА-н газраас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь төсөл хэрэгжүүлэгч яам төслийн нэгжтэй гэрээ байгуулахдаа орон нутгийн төрийн байгууллага, холбогдох албан тушаалтныг оролцуулахгүй байгаатай холбоотой ба журамд орон нутгийн төрийн байгууллагын хяналтын чиг үүргийг тодорхойлоогүй байна.

3.1.2. Орон нутагт зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийн ил тод байдлыг хангаагүй байна.

Аймаг, сумын хэмжээнд тухайн зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн талаар урьдчилсан мэдээлэл хангалтгүй, баримт материалыг архивын нэгж болгож үлдээхгүй байгаа тул хаана ямар төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар мэдээлэл огт байхгүй байна.

Аудитын явцад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэхэд хяналт хийхэд мэдээлээгүй байна.

Хэрэгжсэн төслүүдийн талаарх мэдээллийг төсөл хэрэгжүүлэгч яам гаргаж өгч байгаа нь олон нийтэд ил тод мэдээлэхгүй байгааг харуулж байна.

3.2 Төсөл хэрэгжүүлэгч, төслийн нэгж нь зээл, тусламжийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцсон байна.

3.2.1. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг үнэн зөв тайлагнасан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаал, 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-д заасны дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, эцсийн тайланг боловсруулж тайлагнадаг.

Төслийн орон нутаг хариуцсан зохицуулагчийн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайлангаас харахад зарим төслийн үр дүнг бодит байдлаас зөрүүтэй үнэлж тайлагнасан байна. Тухайлбал Secim төслөөр Тариалан суманд хэрэгжсэн намнангийн ард сүүний нэмүү өртгийн сүлжээний хүрээнд сүүний хөргөлтийн төв байгуулж, нийт 71.5 сая төгрөгөөр суурин болон зөөврийн сүү хөргөх танк нийлүүлж, ард иргэдэд сургалт зохион байгуулж төсөл амжилттай хэрэгжсэн гэж үр дүнг тайлагнасан боловч бодит байдал дээр Тариалан сумын ЗДТГ-ын хашаанд суурин сүүний танк нь ашиглалтгүй, зөөврийн танкийг Хөвсгөл Титаник ХХК-д шилжүүлэн өгсөн сүүний хөргөлтийн төв байгуулаагүй байна.

Аудитын багт гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн болон эцсийн тайлан, хяналт шинжилгээ үнэлгээний тайлан болон холбогдох баримт материал бүрэн байхгүйгээс Хөвсгөл аймагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр

дүнг төсөл арга хэмжээний хэрэгжилтийн болон эцсийн тайланд үнэн зөв тайлагнасан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

3.2.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Хөдөө аж ахуйн салбарт Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд төслийн нэгж, ХХААХҮЯ-ын ХШҮДАГ дотоод хяналт хийж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан гаргаж ХХААХҮЯ болон Төслийн удирдах хороонд тайлагнасан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд улсын хэмжээнд хэрэгжсэн төсөл арга хэмжээг ерөнхий байдлаар үнэлж, орон нутагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнг тусгайлан үнэлээгүй байна.

Аудитаар нийт 324.7 сая төгрөгийн 8 зөрчил илрүүлж, 133.5 сая төгрөгийн 3 албан шаардлага, 191.2 сая төгрөгийн 5 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын нэгдсэн тайланд тусгуулах 3 саналыг тайлангаар хүргүүлж ажиллалаа.

АУДИТЫН НЭГДСЭН ТАЙЛАНД ТУСГУУЛАХ САНАЛ:

1. Гадаадын зээл, тусламжаар орон нутагт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд орон нутгийн төрийн байгууллага, Хөдөө аж ахуйн газар, холбогдох албан тушаалтны оролцоог нэмэгдүүлж, хяналт хэрэгжүүлэх талаар “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-д өөрчлөлт оруулах замаар зээл тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх зөвлөмжийг нэгтгэсэн тайланд тусгах.
2. Тулгат олз ХХК нь Төрийн банкнаас жилийн 13.76 хувийн хүүтэй 10 жилийн хугацаатай 926.0 сая төгрөгийн зээлийг Төрийн банкнаас 2021 оны 3 дугаар сарын 31-нд авснаас Зээлийн батлан даалтын сангаас 420.0 сая төгрөгийг батлан даасан байна. Төрийн банк, Тулгат олз ХХК хооронд хийсэн зээлийн гэрээнд хөргүүртэй 500 тонны зоорь, өвлийн хүлэмж барихаар гэрээнд тусгасан боловч зоорийг бариагүй, тухайн аж ахуйн нэгж нь зээлийн гэрээний дагуу хүү болон үндсэн зээлийг эргэн төлөөгүйгээс одоогийн байдлаар 125.1 сая төгрөг хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, батлан даалтын санг 420.0 сая төгрөгийн эрсдэлд оруулах магадлалтай байна. Зээл авсан Тулгат олз ХХК-ийн гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудтай холбогдох боломжгүй байна. Иймд төсөл хэрэгжүүлэгч байгууллагад Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 9.4.6⁸ заалтын дагуу хандан дээрх зөрчлийг шийдвэрлэх шаардлагатай байна.
3. Бүгд найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банк болон Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Тосонцэнгэл, Мөрөн сумуудад трактор болон дагалдах хэрэгслийг нийлүүлсэн гэж ХХААХҮ-ийн сайдын 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А-238 тоот тушаалын хавсралт болон төслийн нэгжээс ирүүлсэн судалгаанд тусгасан боловч аудитаар хянахад Тосонцэнгэл сумын “Тосон тээлийн өгөөж” хоршоонд 17,935.0 евро буюу 60.3 сая төгрөг, Мөрөн сумын “Дэлгэрэх шимт” хоршоо 35,870 евро буюу 120.6 сая төгрөгийн нийт 180.9 сая төгрөгийн трактор болон бусад дагалдах хэрэгслийг хүлээн аваагүй байна. Иймд төсөл хэрэгжүүлэгчээс тодруулах шаардлагатай байна.

⁸ Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, сонгон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулж, түүний биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн 180.9 сая төгрөгийн хөрөнгийг нийлүүлээгүй, тусламжийн хөрөнгөөр 68.0 сая төгрөгийн хөрөнгийг бүрэн хэрэгжүүлээгүй ба бусад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт 99.1 хувьтай байна.
2. Арилжааны банкаар дамжуулан нийт 1,679 малчдад 16,845.0 сая төгрөгийн зээлийг 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй малчид болон мал бүхий иргэнд олгосон зээл, малчин өрхөд дэмжлэг үзүүлсэн 1,809.9 сая төгрөгийн дэмжлэг нь тухайн үедээ малчдын амьжиргаанд эерэг нөлөө үзүүлсэн боловч урт хугацаанд үр өгөөж өгөх төсөл болж чадаагүй байна.
3. Тусламжийн хөрөнгөөр нийт 1001.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс 194.7 сая төгрөгийн хөрөнгийг төрийн байгууллагад, 806.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд олгосон, 100.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглахгүй байгаа зэрэг нь гадаадын тусламжийг орон нутагт хэрэгцээ шаардлага хангаагүй, бэлтгэл ажил дутуу байхад төсөл хэрэгжүүлсэн болон хувийн хэвшилд олгосон хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг тооцож хяналт тавих субъект тодорхойгүй тул тусламжаар авсан хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг тооцох боломжгүй байна.
4. ХХААХҮЯ, МЭЭГ-аас харьяа байгууллага болон орон нутгийн төрийн байгууллагад ирүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа Улсын төсвийн хөрөнгө оруулалт, байгууллага хооронд үнэ төлбөргүй шилжин ирсэн, Засгийн газрын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн хөрөнгө эсэхийг нь тодорхойлохгүйгээр үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө гэж тусгадаг тул эх үүсвэрийг ялгах боломжгүй, төрийн байгууллагууд гадаадын зээл, тусламжийн хүрээнд хүлээн авсан 96.1 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй байгаа зэрэг нь зээл тусламжийн хөрөнгийн хэрэгжилтэд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
5. Гадаадын зээлээр хэрэгжсэн төслийн хүрээнд тоног төхөөрөмж бэлтгэж, барилга байгууламж барих, засварлах, өргөтгөх ажлуудыг хийсэн, малчдыг дэмжих хөнгөлөлттэй зээл, бичил зээлийг олгосон боловч зарим зээлдэгч нар нь зээлийн зорилгыг бүрэн хангаагүй, зориулалтын дагуу ашиглаагүй, хугацаандаа эргэн төлөлт хийгээгүй, батлан даалтын санг эрсдэлд оруулсан, зарим тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй, орон нутгийн төрийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлэх тогтолцоог хууль, журамд тодорхойлоогүй, орон нутагт ажлын байр хэдээр нэмэгдэж, ядуурлын түвшин яаж өөрчлөгдөж байгааг бодитой тодорхойлж чадахгүй байгаа зэргээс харахад хөнгөлөлттэй зээл, дэмжлэгийн үр дүнд тавих орон нутгийн хяналтын тоглолцоо шаардлагатайг харуулж байна.
6. Гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн болон эцсийн тайлан, хяналт шинжилгээ үнэлгээний тайлан болон холбогдох баримт материал бүрэн байхгүй, Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд улсын хэмжээнд хэрэгжсэн төсөл арга хэмжээг ерөнхий байдлаар үнэлж, орон нутагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнг тусгайлан үнэлээгүй зэргээс Хөвсгөл аймагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг төсөл арга хэмжээний хэрэгжилтийн болон эцсийн тайланд үнэн зөв тайлагнасан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Должинсорогдогт:

Орон нутгийн төрийн байгууллагуудын гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс хүлээн авсан үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй **71.1** сая төгрөгийн 13 хөрөнгийг холбогдох байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгуулж, орон нутгийн өмчөөр бүртгэх:

Мал эмнэлгийн газрын дарга Л.Ариунаад:

Ногоон алт-Малын эрүүл мэнд төслөөс хэрэгжүүлсэн Цэцэрлэг сумын мал эмнэлгийн барилгын өртгийг 25.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэх.

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхтөрд:

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс хүлээлгэн өгсөн 27.1 сая төгрөгийн өвлийн хүлэмжийг түрээсийн гэрээ хийж иргэн, ААН-д төслийн зориулалтын дагуу ашиглуулах

Эрдэнэбулган сумын Засаг дарга Б.Эрдэнэнаранд:

Эрдэнэбулган суманд махны нэмүү өртгийн сүлжээний төслийн хүрээнд хүлээлгэн өгсөн 16.0 сая төгрөгийн мал нядалгааны жижиг үйлдвэрийн шугамыг ашиглалтад оруулах талаар хяналт тавьж ажиллах

Тариалан сумын Засаг дарга Х.Эгиймаад:

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын SECIM төслөөр Тариалан суманд сүүний нэмүү өртгийн сүлжээний хүрээнд 52.0 сая төгрөгийн 5 тонны сүүний хөргөлтийн танкийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, төслийн зориулалтын дагуу ашиглах

Зөрчлийн нэгтгэл

/сая.төг/

Зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс олгосон Хөвсгөл аймгийн Их-Уул суманд 60м2 өвлийн хүлэмжийг түрээсийн гэрээ хийхгүйгээр иргэнд үнэ төлбөргүй ашиглуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.	1	27.1					1	27.1
Хөвсгөл аймагт хэрэгжсэн гадаадын тусламжаар хүлээн авсан дараах хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. • Мерси кор ОУБ-ын санхүүжилтээр нийлүүлсэн 51.2 сая төгрөгийн вакцины хөргүүрийг 12 сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна. • Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс 19.9 сая төгрөгийн өртөгтэй худгийг Бүрэнтогтох сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Өрийн удирдлагын тухай хуулийн 24.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4, - дахь заалттай нийцэхгүй байна	1	71.1					1	71.1
НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын SECIM төслөөр Тариалан суманд сүүний нэмүү өртгийн сүлжээний хүрээнд 52.0 сая төгрөгийн 5 тонны сүүний хөргөлтийн танкийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, ашиглахгүй байна.	1	52.0					1	52.0
НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган суманд махны нэмүү өртгийн сүлжээний хүрээнд 16.0 сая төгрөгийн мал нядалгааны жижиг үйлдвэрийн шугамыг ашиглалтад оруулахад үйлдвэрийн барилгын ажил дутуу байгаагаас одоог хүртэл ашиглаж эхлээгүй байна.	1	16.0					1	16.0
Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн санхүүжүүлэлт, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд мал эмнэлгийн цогцолбор Цэцэрлэг суманд баригдсан мал эмнэлгийн барилгыг аймгийн Мал эмнэлгийн газрын нягтлан бодох	1	25.0					1	25.0

бүртгэлд 45.0 сая төгрөгийн өртөгтэй барилгыг 25.0 сая төгрөгөөр дутуу тусгасан байна. Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 24.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4, - дахь заалттай нийцэхгүй байна								
Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох сумын малчны 24 бүлэгт дундын сангийн үйл ажиллагаа, зарцуулалтад гэрээнд заасны дагуу сумын Засаг дарга хяналт хэрэгжүүлээгүй байна.	3	133.5			3	133.5		
Дүн	8	324.7			3	133.5	5	191.2

Аудитын тайлангийн төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

Цэцэрлэг сумын Засаг даргаас ирсэн санал


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**
Цэцэрлэг сум, Хөвсгөл аймаг, 67320
Цахим шуудан: Tsetserlegzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: http://tsetserleg.khs.gov.mn

2023.8.17 № 2/162
Танай _____ -ны № _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөл дээр нэмэх зүйл байхгүй.

ОРЛОГЧ  Д.ОТГОНБАЯР

Санал тайлбар ирүүлээгүй

C:\Users\Del\Documents\Засаг дарга А5.docx
673202830392


Тариалан сумын ЗДТГ-аас ирүүлсэн санал, тайлбар


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТАРИАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**
Тариалан сум, Хөвсгөл аймаг, 67010
Утас: 7038 6008, Цахим шуудан: Tarialanzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: http://tarialan.khs.gov.mn

2023.08.17 № 3/579
Танай 2023.08.16 -ны № 01/579 -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Тус суманд НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын SECIM төслийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 5тоннын сүүний хөргөлтийн танкыг бусдад худалдан борлуулах боломжгүй.
Бид орон нутагтаа жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжиж ажлын байр бий болгох зорилгоор ашиглахаар төлөвлөж байгаа болно.

ДАРГА  Д.БААСАНБАТ

673202830392

Санал, тайлбарыг хүлээн авч тайлан, зөвлөмжид өөрчлөлт орууллаа.

Их-Уул сумын ЗДТГ-аас ирүүлсэн санал, тайлбар

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИХ-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

Их-Уул сум, Хөвсгөл аймаг, 67050
Утас: 7038 6705, Цахим шуудан: ihuulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: <http://ikh-uul.khs.gov.mn>

2023.08.17 № 03/190
танай 2023.08.16 -ны № 01/498 -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөж” гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Өгсөн зөвлөмжийн дагуу “Өвлийн хүлэмж”-ийг ашиглагч Ц.Эрхэмзаяатай түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байгаа. Өөр санал хүсэлт, тайлбар үгүй болно.

ДАРГА  ДЭНХТӨР

Түрээсийн гэрээ байгуулсан нотлох баримтыг ирүүлээгүй тул тайлбарыг хүлээн авах боломжгүй

Цэцэрлэг сумаас ирүүлсэн санал, тайлбар

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

Цэцэрлэг сум, Хөвсгөл аймаг, 67320
Цахим шуудан: Tsetserlegzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: <http://tsetserleg.khs.gov.mn>

2023.8.17 № 2/162
танай -ны № -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөл дээр нэмэх зүйл байхгүй.

ОРЛОГЧ  Д.ОТГОНБЯАР

Санал тайлбар байхгүй

Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн санал, тайлбар



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР**


АЗДТГ-ын байр А корпус 1 давхар,
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 8849, 7038 8821, Факс: 7038 8848
Цахим шуудан: khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http://umch.khs.gov.mn


2024.08.17 № 3/591
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитаар ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Холбогдох тайлбар, саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт .1. хуудастай.



АХЛАХ МЭРГЭЖИТЭН  Х.МӨНХ-ЭРДЭНЭ

Санал тайлбарыг хүлээн авч тайлан, зөвлөмжид өөрчлөлт орууллаа.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудит

Аудитын код: АГГ-2023/25-ШТА/ГА

Байгууллагын нэр: Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдвэр	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5		6		
1	“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж	Зах зээл бэлчээрийн удирдлагын төслийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн тус сумын ЗДТГ-т 19.9 сая төгрөгийн гүн өрмийн худгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ... 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, ... 14.4.5-“бүх орлого” гэсэн заалттай нийцэхгүй байна.	19,900,000	Гүн өрмийн худгийг сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлд бүртгүүлэх, зөвлөмж өгөх	Олон улсын зээл тусламжаар санхүүжсэн хөрөнгө нь манай газраар дамжин олгогдоогүй, гэрээг байгуулж ажиллаагүй, мэдээлэл дутмаг байна. Гүн өрмийн худгийг сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлд бүртгүүлэх, зөвлөмж өгч ажиллана.				
2	“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын SECIM төслөөр Тариалан суманд сүүний нэмүү өртгийн сүлжээний хүрээнд 52.0 сая төгрөгийн 5 тонны сүүний хөргөлтийн танкийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, ашиглахгүйгээр ЗДТГ-ын хашаанд хадгалж байна.	52,000,000	5 тонны сүүний хөргөлтийн танкийг сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлд бүртгүүлэх, ашиглахгүй бол хэрэгцээт газарт нь шилжүүлэх зөвлөмж өгөх	Олон улсын зээл тусламжаар санхүүжсэн хөрөнгө нь манай газраар дамжин олгогдоогүй, гэрээг байгуулж ажиллаагүй, мэдээлэл дутмаг байна. 5 тонны сүүний хөргөлтийн танкийг сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлд бүртгүүлэх, ашиглахгүй бол хэрэгцээт газарт нь шилжүүлэх зөвлөмжийг өгч ажиллана.				
Нийт дүн			71,900,000						

Бүрэнтогтох сумын Засаг даргаас ирүүлсэн санал



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БҮРЭНТОГТОХ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**
Бүрэнтогтох сум, Хөвсгөл аймаг, 67220
Утас: 7038 0038, Цахим шуудан: Btgotkhzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: http://burentogtokh.khs.gov.mn
2023.08.17 № 1/195
танай _____ -ны № _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Санал тайлбар байхгүй

Тус суманд хэрэгжсэн “Хөдөө аж ахуйн зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөж” тайлангийн төсөлтэй танилцав.

Тайлантай холбоотой санал байхгүй болно.

ОРЛОГЧ  Э.АРИУНТУНГАЛАГ

Мал эмнэлгийн газраас ирүүлсэн санал, тайлбар


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗАР**
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 2788 Цахим шуудан: khuvs gul@vet.gov.mn
2023.08.17 № 01/100
танай 2023.08.16 -ны № 61/481 -т


**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Санал тайлбар байхгүй

Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн “Хөдөө аж ахуйн зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.


Аудитын тайлангаар өгөгдөх зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

Жич: Холбогдох санал байхгүй.

ДАРГА  Л.АРИУНАА



ХХААГ-аас газраас ирүүлсэн санал, тайлбар




Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас ицэтгэсэн “Хөдөө аж ахуйн зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитын илантай танилцлаа.

Санал тайлбар байхгүй

Тус тайлантай холбоотой санал байхгүй лно.

ДАРГА  Я.ЭРХЭМБАЯР
2023.08.23 09:36


Хөвсгөл аймгийн Засаг даргаас ирүүлсэн санал



Санал тайлбар байхгүй

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн “Хөдөө аж ахуйн зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тухайн төсөлд өгөх санал байхгүй болно.

ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР
2023.08.23 09:36

Цагаан-Уул сумын Засаг даргад өгсөн албан шаардлага



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 17 өдөр

№ 94/А2260468/ХӨА-2023/25-
-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс Цагаан-Уул суманд 8 бүлэгт нийт 48,571,773 (Дөчин найман сая таван зуун далан нэгэн мянга долоон зуун далан гурав) төгрөгийн дундын сан байгуулж өгсөн ба бүлгийн гишүүн болох малчин өрх сангаас зээл авч байх зориулалттай, сумын удирдлагаас бүлэг болон дундын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх, үүрэгтэй байхаар “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн дэмжлэгтэй малчдын бүлгийн дундын сангийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх гэрээнд тусгасан байна. Гэвч малчдын бүлгийн дундын сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт тодорхойгүй, сумын удирдлагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5-д “Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль, тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх”, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана”, Цагаан-Уул сумын Засаг даргын баталсан малчны бүлэгтэй байгуулсан гэрээнд “... Сумын захиргаа нь малчдын бүлэг болон бүлгийн дундын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8, 4.2.1.11-д заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Малчны бүлгийн дундын сангийн үйл ажиллагаа, 48,571,773 (Дөчин найман сая таван зуун далан нэгэн мянга долоон зуун далан гурав) төгрөгийн хөрөнгийн ашиглалтад хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

2. Малчдын дундын сангийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, сангийн хөрөнгө дутагдсан бол буруутай этгээдүүдээр төлүүлж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Цагаан-Уул сумын Засаг дарга С.Гончигнямд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Д.ОТГОНБАЯР



Цэцэрлэг сумын Засаг даргад өгсөн албан шаардлага



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 17 өдөр

№ 92/А-2260468/ХӨА-2023/
25-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс Цэцэрлэг суманд 7 бүлэгт нийт 37,600,200 (Гучин долоон сая зургаан зуун мянга хоёр зуу) төгрөгийн дундын сан байгуулж өгсөн ба бүлгийн гишүүн болох малчин өрх сангаас зээл авч байх зориулалттай, сумын удирдлагаас бүлэг болон дундын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх, үүрэгтэй байхаар “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн дэмжлэгтэй малчдын бүлгийн дундын сангийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх гэрээнд тусгасан байна. Гэвч малчдын бүлгийн дундын сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт тодорхойгүй, сумын удирдлагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5-д “Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль, тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх”, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана”, Цэцэрлэг сумын Засаг даргын баталсан малчны бүлэгтэй байгуулсан гэрээнд “... Сумын захиргаа нь малчдын бүлэг болон бүлгийн дундын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8, 4.2.1.11-д заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Малчны бүлгийн дундын сангийн үйл ажиллагаа, 37,600,200 (Гучин долоон сая зургаан зуун мянга хоёр зуу) төгрөгийн хөрөнгийн ашиглалтад хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 301, тоот Утас:70384043

2. Малчдын дундын сангийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, сангийн хөрөнгө дутагдсан бол буруутай этгээдүүдээр төлүүлж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Цэцэрлэг сумын Засаг дарга Н.Анхбаярт даалгав.



Бүрэнтогтох сумын Засаг даргад өгсөн албан шаардлага



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 17 өдөр

№ 93/А 2260468/ХӨА-2023/25-
- 21 - ШТА - ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс Бүрэнтогтох суманд 8 бүлэгт нийт 47,293,600 (Дөчин долоон сая хоёр зуун ерэн гурван мянга зургаан зуу) төгрөгийн дундын сан байгуулж өгсөн ба бүлгийн гишүүн болох малчин өрх сангаас зээл авч байх зориулалттай, сумын удирдлагаас бүлэг болон дундын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх, үүрэгтэй байхаар “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн дэмжлэгтэй малчдын бүлгийн дундын сангийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх гэрээнд тусгасан байна. Гэвч малчдын бүлгийн дундын сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт тодорхойгүй, сумын удирдлагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5-д “Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль, тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх”, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана”, Бүрэнтогтох сумын Засаг даргын баталсан малчны бүлэгтэй байгуулсан гэрээнд “... Сумын захиргаа нь малчдын бүлэг болон бүлгийн дундын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8, 4.2.1.11-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Малчны бүлгийн дундын сангийн үйл ажиллагаа, 47,293,600 (Дөчин долоон сая хоёр зуун ерэн гурван мянга зургаан зуу) төгрөгийн хөрөнгийн ашиглалтад хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

2. Малчдын дундын сангийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, сангийн хөрөнгө дутагдсан бол буруутай этгээдүүдээр төлүүлж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Бүрэнтогтох сумын Засаг дарга Л.Аззаяад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР
Д.ОТГОНБАЯР

